


# ❁ НОМИН ЮНИТИ ББСБ ХХК

2024 оны 04 дугаар  
сарын 08 -ны өдөр

№: 34/24

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



### Журам батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дэх хэсэг, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. "Номин Юнити ББСБ" ХХК-ийн "Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам"-ыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ХОСБАЯР



 <b>НОМИН</b>	"НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК	Дугаар: 4/2024-6/04	Иш татсан заалт: ISO 9001: 7.5
<b>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ</b>		Хувилбар: 1	



Хувилалт №.

### БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ

Хувилбар	Товч утга	Батлагдсан огноо, тушаалын дугаар	Мөрдөж эхлэх огноо
Хувилбар 1	Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам	2024.07.08 №34/24	2024.07.08

### ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

Д/ д	Баримт бичгийн дугаар	Нэр
1	2002.01.10	Иргэний хууль
2	2002.12.12	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
3	2013.05.31	Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
4	НУТ-1/001	Бичиг баримт боловсруулах журам


### ГАРЧИГ

Агуулга	Хуудас
1. Нийтлэг үндэслэл	2-2
2. Нэр томьёо, тайлбар	2-2
3. Мэдээллийг ил тод нийтлэх, тайлагнахад баримтлах зарчим	2-2
4. Мэдээллийн ил тод байдлыг хангах	3-3
5. Мэдээлэл, түүний ангилалт зориулалт	4-4
6. Мэдээллийн нууцлал, боловсруулалт	4-5
7. ББСБ-ын цахим хуудсанд мэдээлэл байршуулах, мэдээлэл түгээх хугацаа	5-5
8. Цахим хуудасны мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах	5-6
9. Хариуцлага	6-6

Хуудас 1 / 6

Ашиглахын өмнө хүчинтэй хувилбар мөн эсэхийг шалгана уу



 <b>НОМИН</b>	"НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК	Дугаар: ҮАЖ/4-6/04	Иш татсан заалт: ISO 9001: 7.5
<b>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ</b>		Хувилбар: 1	


### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (цаашид "Журам" гэх)-ын зорилго нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодексад нийцүүлэн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болон бусад оролцогч этгээдэд "НОМИН Юнити ББСБ" ХХК (цаашид "ББСБ" гэх)-ийн үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хүргэх, компани нь хууль тогтоомж, дүрэм журамд заасан болон бусад мэдээллийг нээлттэй болгох, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ББСБ нь холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллага, харилцагчийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг ашиглах хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, эрх тэгш байх, нийтэд хүргэх үйл ажиллагаа нь шуурхай, ойлгомжтой, үнэн зөв, бүрэн гүйцэт байх зарчмыг баримтлана.
- 1.3. ББСБ нь харилцагчид өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн нөхцөлийг үнэн зөвөөр хүргэх зорилгоор өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж нийтэд хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

### ХОЁР. НЭР ТОМЬЁО, ТАЙЛБАР

- 2.1. Энэхүү журамд дурдагдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
  - 2.1.1. "Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэл" гэж ББСБ-ын үйл ажиллагааны хүрээнд боловсруулж, цуглуулж, ашиглаж буй нийтэд зориулагдсан, хувилах, хадгалах, дамжуулах, гарган өгөхөд тусгай шаардлага тавихгүй мөн Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд нийтэд ил болгосон мэдээллийг;
  - 2.1.2. "Мэдээллийг ашиглах" гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцахыг;
  - 2.1.3. "Мэдээллийг боловсруулах" гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэрийг;
  - 2.1.4. "Мэдээлэл цуглуулах" гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;
  - 2.1.5. "Харилцагч" гэж ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг авч байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг;
  - 2.1.6. "Санхүүгийн бус тайлан" гэж ББСБ өөрийн стратеги, үйл ажиллагааны зорилтуудад хүрэхийн тулд ямар үр дүн гаргаж буй талаарх мэдээллийг агуулсан тайлан, мэдээг.



 <b>НОМИН</b>	"НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК	Дугаар: ҮАЖ/4-6/04	Иш татсан заалт: ISO 9001: 7.5
<b>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ</b>		Хувилбар: 1	


### **ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД НИЙТЛЭХ, ТАЙЛАГНАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

- 3.1. ББСБ нь мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлагнах үйл ажиллагаанд дараах зарчмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:
- 3.1.1. Олон нийтийн мэдээлэлд хандах эрхийг хүртээмжтэй байлгах. Олон нийтийн зүгээс ББСБ-ын нээлттэй мэдээлэлд хандах, түүнтэй танилцах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 3.1.2. Мэдээлэл нь үнэн зөв, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэгдсэн байх. ББСБ-ын үйл ажиллагааны мэдээ, санхүүгийн болон санхүүгийн бус тайлан, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл болон бусад нээлттэй мэдээллүүд нь хоёрдмол утга агуулаагүй, үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл байна.
- 3.1.3. Хуульд заасан хугацааг баримтлах. Хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан ББСБ-ын үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон бусад холбогдох тайланг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй байршуулна.
- 3.1.4. Мэдээлэлд тогтмол нэмэлт, өөрчлөлт оруулах. Хууль тогтоомж өөрчлөгдсөн, үйл ажиллагаа өөрчлөгдсөн, шинэ технологийн шийдэл нэвтрүүлсэн зэрэг аливаа шалтгааны улмаас өмнө нь нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүрд нь мэдээлэлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

### **ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ**

- 4.1. ББСБ-ын мэдээллийн ил тод байдлыг хангах, тайлагнах чиг үүргийг дараах бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.1.1. **Төлөөлөн удирдах зөвлөл.** Компанийн засаглалын кодекст заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг хангах буюу энэхүү журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах, Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан болон засаглалын баримт бичгүүдийн ил тод байдлыг хангуулах;
- 4.1.2. **Гүйцэтгэх захирал.** ББСБ-ын мэдээллийн зэрэглэлийг тогтоож, нээлттэй мэдээллийн жагсаалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлах, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах болон ББСБ-ын мэдээллийг нийтэд нээлттэй байршуулах болон төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэх тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах;
- 4.1.3. **Санхүү, тайлан бүртгэлийн алба.** Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд холбогдох мэдээллийг холбогдох газар, нэгжүүдээр гаргуулан нэгтгэж, зохицуулагч байгууллага болон бусад шаардлагатай байгууллагуудад илгээх;




 <b>НОМИН</b>	"НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК	Дугаар: ҮАЖ/4-6/04	Иш татсан заалт: ISO 9001: 7.5
<b>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ</b>		Хувилбар: 1	

- 4.1.4. **Бизнес хөгжлийн алба.** ББСБ-ын нийтэд мэдээлэх мэдээллийг ББСБ-ын цахим хуудсанд байршуулах, цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тогтмол шинэчлэх;
- 4.2. ББСБ нь нээлттэй мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудас [/https://www.nominunity.mn/](https://www.nominunity.mn/)-нд байршуулж, олон нийтийг тухай бүр танилцах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **ТАВ. МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ АНГИЛАЛТ ЗОРИУЛАЛТ**

- 5.1 ББСБ-с боловсруулан гаргаж буй мэдээлэлд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, санхүүгийн тайлан болон хөрөнгө оруулагчид эсвэл бусад этгээд мэдвэл зохих бусад мэдээллүүд багтана.
- 5.2 ББСБ-с боловсруулан гаргаж буй мэдээллүүд нь түүний зориулалт, нууцлалын шаардлагаас хамаарч дараах үндсэн ангилалтай байна. Үүнд:
- 5.2.1 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэл
- 5.2.2 Нууц мэдээлэл
- 5.3 **Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэлд** Монгол улсын зохих хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон нийтэд түгээх ББСБ-ын хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан зэрэг мэдээллүүд буюу дараах мэдээллүүд багтана. Үүнд:
- 5.3.1 ББСБ-ын зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
- 5.3.2 ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орсон өөрчлөлт;
- 5.3.3 ББСБ-ын ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл;
- 5.3.4 ББСБ-ын хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
- 5.3.5 ББСБ-ын удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
- 5.3.6 Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулга, дүгнэлт;
- 5.3.7 Тайлант хугацаанд ББСБ-ын үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
- 5.3.8 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
- 5.3.9 Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс-д тухай бүр нээлттэй мэдээлэхээр тусгасан бусад мэдээлэл;
- 5.4 Компанийн нууцын журамд заасан байгууллагын болон Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан мэдээллийг шүүх, цагдаа, татвар зэрэг төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд мэдээллэхгүй.



 <b>НОМИН</b>	"НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК	Дугаар: ҮАЖ/4-6/04	Иш татсан заалт: ISO 9001: 7.5
<b>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ</b>		Хувилбар: 1	


### ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, БОЛОВСРУУЛАЛТ

- 6.1 ББСБ-ын мэдээллийг ангилах, хадгалах, өөрчлөх зэрэг мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001:2021 стандарт, ББСБ-ын Мэдээллийн аюулгүй байдлын журмыг дагаж мөрдөнө.
- 6.2 ББСБ нь мэдээллийг боловсруулах ажиллагаанд бүрэн, бодит баримт мэдээлэлд үндэслэгдсэн, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.
- 6.3 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээллийг ББСБ-ын тухайн асуудлыг хариуцсан чиг үүрэг бүхий албан тушаалтан, албаны дарга хариуцан гаргаж Гүйцэтгэх удирдлагад шуурхай хүргэнэ.
- 6.4 Мэдээллийн үнэн бодит байдлыг мэдээлэл гаргасан нэгжийн дарга болон Гүйцэтгэх удирдлага хариуцах бөгөөд ББСБ-ын Дотоод хяналт хариуцсан ажилтан, ТУЗ тавина.
- 6.5 Мэдээлэл боловсруулагч болон олж авсан ажилтан нь мэдээллийг энэхүү журамд заасан нөхцөл, хугацаагаар нийтэд мэдээллэх хүртэл мэдээллийн нууцлалыг хариуцан ажиллах үүрэгтэй.

### ДОЛОО. ББСБ-ЫН ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ХУГАЦАА

- 7.1 ББСБ нь мэдээллийг холбогдох нэгж буюу нэгжийн хамтын ажиллагааны үндсэн дээр үнэн зөв, албан ёсны эх сурвалжуудыг ашиглан боловсруулах ба цахим хуудсанд энэхүү журамд заасан мэдээллийг байршуулах, мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд холбогдох мэдээллийг шинэчлэх, устгах, цахим хуудасны хэвийн ажиллагааг хангах үүргийг ББСБ-ын Бизнес хөгжлийн алба хэрэгжүүлнэ.
- 7.2 Бизнес хөгжлийн алба нь цахим хуудсанд мэдээлэл байршуулах, шинэчлэх, өөрчлөх, устгахдаа Гүйцэтгэх удирдлагаас зөвшөөрөл авна.
- 7.3 Бизнес хөгжлийн албаны үйл ажиллагаанд Гүйцэтгэх удирдлага хяналт тавина.
- 7.4 Мэдээллийг (ойлгомжтой байдлаар цахим хуудсанд байршуулах ба цахим хуудас дахь мэдээллийн сангаас энэхүү журамд заасан нээлттэй мэдээлэлтэй иргэн, хуулийн этгээд саадгүй танилцах нөхцөлийг бүрдүүлнэ
- 7.5 Цахим хуудсанд байршуулах мэдээллийг видео, аудио хэлбэрээр байршуулж болно.
- 7.6 Цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд нь холбогдох мэдээллийг шинэчлэн байршуулна.
- 7.7 ББСБ нь хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор өөрийн цахим хуудсанд байршуулна.
- 7.8 ББСБ нь жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 2 дугаар сарын 28-ны өдрийн дотор өөрийн цахим хуудсанд байршуулна.
- 7.9 Олон нийтэд нээлттэй түгээх мэдээлэл, аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн өөрчлөлт болсноос хойш ажлын 3 өдрийн дотор, бүтээгдэхүүн, үйлчилгээнд орсон өөрчлөлтийг ажлын 1 өдөрт багтаан өөрийн цахим хуудсанд байршуулна.



 <b>НОМИН</b>	"НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК	Дугаар: ҮАЖ/4-6/04	Иш татсан заалт: ISO 9001: 7.5
<b>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ</b>		Хувилбар: 1	

- 7.10 ББСБ-ын цахим хуудсанд байршуулсан мэдээллийг албан ёсны мэдээлэл гэж үзэх тул иргэн, хуулийн этгээд нь сургалт, судалгаа шинжилгээ, мэдээллийн зорилгоор ашиглаж болно.

### **НАЙМ. ЦАХИМ ХУУДАСНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ**

- 8.1 ББСБ-ын Бизнес хөгжлийн алба нь цахим хуудасны системд нэвтрэх эрхийн нууцлалыг хангах үүрэг хүлээнэ.
- 8.2 Цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын зөрчил, тохиол гарсан нөхцөлд ББСБ-ын Мэдээллийн аюулгүй байдлын журамд заасан арга хэмжээг авч, нэн даруй шалтгааныг нь тодруулан шаардлагатай гэж үзвэл холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэж, хамтран ажиллана.
- 8.3 ББСБ-ын Бизнес хөгжлийн алба нь цахим хуудсанд мэдээлэл байршуулах, шинэчлэх, өөрчлөхдөө гагцхүү албан ёсны эх сурвалж, шийдвэрийг үндэслэх бөгөөд мэдээллийг гуравдагч этгээд байршуулах, өөрчлөх, устгахаас сэргийлж бүхий л шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
- 8.4 Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан ISO/IEC 27001 стандартыг мөрдөнө.

### **ЕС. ХАРИУЦЛАГА**

- 9.1 Энэхүү журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй бол ББСБ нь холбогдох хууль, хяналтын байгууллагад хандаж шалгуулна.
- 9.2 Энэхүү журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүйд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран ББСБ нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.
- 9.3 Энэхүү журмыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ББСБ-д аливаа хохирол учирсан тохиолдолд тухайн ажилтан хохирлыг бүрэн хариуцаж, барагдуулна.

----- оОо -----